



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2023/22/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баруун-Урт сум

2023 он

Миндуг Аудит ХХК
Гүйцэтгэх захирал С.Энхтөр
Утас: 95957791
Цахим хаяг: director@mindug.mn

Аудитын менежер Ц.Номингоо
Утас: 90098901
Цахим хаяг: coo@mindug.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	Error! Bookmark not defined.
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал.....	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.5.1 Завсрын аудитын талаар	14
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	15

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ШША	Шүүхийн шинжилгээний алба
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УТХО	Улсын Төсвийн Хөрөнгө Оруулалт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

**СҮХБААТАР АЙМГИЙН ШҮҮХ
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА
Г.ИДЭРБАТ ТАНАА**

2023.02.24 № 43
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Шүүх шинжилгээний хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Шүүх шинжилгээний хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойшхи үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал өмнөх оноос 34.3 сая төгрөгөөр буюу 15 хувиар өссөн байна. Цалингийн зардал 3.1 сая төгрөгөөр буурсан боловч нэмэгдэл цалин 13,6 сая төгрөг, унаа хоолны нэмэгдэл 4.5 сая төгрөг, урамшууллын зардал 2.0 сая төгрөгөөр тус тус өсжээ.

Аудитын гол асуудал

Сүхбаатар аймгийн Шүүх шинжилгээний хэлтсийн үйл ажиллагаа, тайлант хугацаанд гарсан ажил гүйлгээ, үйл явдал болон засаглах эрх бүхий этгээдүүдийн түвшин дэх харилцаатай холбоотойгоор "Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 300,072.3 мянган төгрөг болж, 99,151.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд ТӨБЗГ-ын 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 449 дүгээр тогтоолоор "Хөдөө аж ахуйг дэмжих сан"-гийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй байсан 151.9 сая төгрөгийн үнэ бүхий Сонато-7 маркийн 28-47 УНУ улсын дугаартай автомашин болон бусад машин тоног төхөөрөмж балансаас балансад шилжүүлэн авч, ТӨБЗГ-ын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А-1/2482 тоот албан тоотод заагдсан

31.9 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй 04-96 СҮА улсын дугаартай пургон маркийн автомашиныг Ховд аймгийн Шүүхийн шинжилгээний албанд хүлээлгэн өгсөн"-өөс өөрөөр санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 11 хөтөлбөр, зорилтын хүрээнд 54 арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилтийг 96.0 хувьтай биелсэн гэж үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1 033 900,00</u>	<u>1 323 300,00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	2 747 900,00	3 299 400,00
351	Түүхий эд материал	1 714 000,00	1 976 100,00
35110	Тусгай зориулалттай материал	127 000,00	127 000,00
35130	Эм боох материал	1 587 000,00	1 849 100,00
354	Хангамжийн материал	1033900,00	1323300,00
35410	Бичиг хэргийн материал	123 000,00	178 500,00
35420	Аж ахуйн материал	80 900,00	80 900,00
35450	Барилгын засварын материал	36 000,00	36 000,00
35470	Бусад хангамжийн материал	307 000,00	1 027 900,00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>200 921 004,51</u>	<u>300 072 325,00</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	200 921 004,51	300 072 325,00
392	Биет хөрөнгө	181 906 004,51	281 057 325,00
39201	Барилга, байгууламж, орон сууц	151 988 950,00	151 988 950,00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-12 368 398,88	-16 581 032,24
39203	Авто-тээврийн хэрэгсэл	31 900 000,00	151 900 000,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-15 950 000,16	-43 700 000,00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	48 739 932,40	69 608 042,40
39206	Хуримтлагдсан элэгдэл	-25 947 461,43	-36 694 392,47
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	7 748 214,29	9 457 214,29
39208	Хуримтлагдсан элэгдэл	-4 205 231,71	-4 921 456,98
39214	Бусад үндсэн хөрөнгө	6 075 000,00	6 075 000,00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-6 075 000,00	-6 075 000,00
393	Биет бус хөрөнгө	19 015 000,00	19 015 000,00
39303	Бусад биет бус хөрөнгө	19 015 000,00	19 015 000,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>203 668 904,51</u>	<u>303 371 725,00</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>203 668 904,51</u>	<u>303 371 725,00</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	203 668 904,51	303 371 725,00
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	137 214 500,00	137 214 500,00
51101	Өмч: - төрийн	137 214 500,00	137 214 500,00
512	Хуримтлагдсан үр дүн	65 037 277,63	164 740 098,12
51210	Өмнөх үеийн үр дүн	65 037 277,63	65 037 277,63
51220	Тайлант үеийн үр дүн	00,00	99 702 820,49
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1 417 126,88	1 417 126,88
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>203 668 904,51</u>	<u>303 371 725,00</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	173 628 600,00	337 565 012,90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3 777 000,00	132 093 212,90
120	Нийтлэг татварын бус орлого	3 777 000,00	132 093 212,90
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3 777 000,00	3 952 000,00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3 777 000,00	3 952 000,00
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/		
120012	Эрхийн шимтгэлийн орлого /ТӨҮГ/		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	169 851 600,00	205 471 800,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	165 684 800,00	195 962 300,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	165 684 800,00	195 962 300,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4 166 800,00	9 509 500,00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2 000 000,00	7 000 000,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2 166 800,00	2 509 500,00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	192 880 775,55	227 213 859,29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	192 880 775,55	227 213 859,29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	192 015 220,55	226 239 766,83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	139 220 474,00	156 253 508,00
210101	Үндсэн цалин	91 659 719,00	88 532 800,00
210102	Нэмэгдэл	40 667 566,00	54 286 500,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6 893 189,00	11 433 708,00
210104	Урамшуулал	00,00	2 000 500,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3 088 500,00	3 309 916,86
210201	Тэтгэврийн даатгал	309 489,56	505 954,86
210202	Тэтгэмжийн даатгал	8 199,87	59 523,88
210203	ҮОМШӨ-ний даатгал	6 559,90	47 619,11
210204	Ажилгүйдлийн даатгал	1 639,97	11 904,77
210205	Эрүүл мэндийн даатгал	2 762 610,70	2 684 914,24
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12 637 818,00	12 123 441,68
210301	Гэрэл, цахилгаан	849 950,00	820 622,68
210302	Түлш, халаалт	10 700 328,00	10 647 780,00
210303	Цэвэр, бохир ус	1 087 540,00	655 039,00
2104	Хангамж, бараа материалын зардал	6 445 230,00	11 554 012,00
210401	Бичиг хэрэг	2 076 340,00	3 000 750,00
210402	Тээвэр, шатахуун	2 672 020,00	5 829 573,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1 000 000,00	944 983,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	696 870,00	1 778 706,00
2105	Нормативт зардал	1 852 320,00	1 412 148,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1 852 320,00	1 412 148,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3 710 210,00	10 799 660,00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	489 410,00	584 400,00
210604	Урсгал засвар	3 220 800,00	10 215 260,00
2107	Томилолт, зочны зардал	1 896 000,00	3 252 000,00
210702	Дотоод албан томилолт	1 896 000,00	3 252 000,00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3 969 173,00	7 484 521,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3 599 468,00	5 946 921,00
210803	Даатгалын үйлчилгээ	150 000,00	457 100,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00,00	1 000 000,00
210807	Газрын төлбөр	79 705,00	80 500,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19 195 495,55	20 050 559,29
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	19 195 495,55	20 050 559,29
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	865 555,00	974 092,46
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	865 555,00	974 092,46
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-19 252 175,55	110 351 153,61
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00,00	10 648 333,12
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00,00	10 648 333,12
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00,00	-10 648 333,12
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-19 252 175,55	99 702 820,49

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	173 628 600,00	209 423 800,00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3 777 000,00	3 952 000,00
120	Нийтлэг татварын бус орлого	3 777 000,00	3 952 000,00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3 777 000,00	3 952 000,00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3 777 000,00	3 952 000,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	169 851 600,00	205 471 800,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	165 684 800,00	195 962 300,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	165 684 800,00	195 962 300,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4 166 800,00	9 509 500,00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2 000 000,00	7 000 000,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2 166 800,00	2 509 500,00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	173 628 600,00	207 714 800,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	173 628 600,00	207 714 800,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	172 763 045,00	206 740 707,54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	139 220 474,00	156 253 508,00
210101	Үндсэн цалин	91 659 719,00	88 532 800,00
210102	Нэмэгдэл	40 667 566,00	54 286 500,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6 893 189,00	11 433 708,00
210104	Урамшуулал	00,00	2 000 500,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3 088 500,00	3 309 916,86
210201	Тэтгэврийн даатгал	309 489,56	505 954,86
210202	Тэтгэмжийн даатгал	8 199,87	59 523,88
210203	ҮОМШӨ-ний даатгал	6 559,90	47 619,11
210204	Ажилгүйдлийн даатгал	1 639,97	11 904,77
210205	Эрүүл мэндийн даатгал	2 762 610,70	2 684 914,24
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12 637 818,00	12 123 441,68
210301	Гэрэл, цахилгаан	849 950,00	820 622,68
210302	Түлш, халаалт	10 700 328,00	10 647 780,00
210303	Цэвэр, бохир ус	1 087 540,00	655 039,00

2104	Хангамж, бараа материалын зардал	6 485 150,00	11 122 512,00
210401	Бичиг хэрэг	1 989 260,00	3 056 250,00
210402	Тээвэр, шатахуун	2 799 020,00	5 342 573,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1 000 000,00	944 983,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	696 870,00	1 778 706,00
2105	Нормативт зардал	1 819 720,00	1 674 248,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1 819 720,00	1 674 248,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3 746 210,00	11 520 560,00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	489 410,00	592 700,00
210604	Урсгал засвар	3 256 800,00	10 927 860,00
2107	Томилолт, зочны зардал	1 896 000,00	3 252 000,00
210702	Дотоод албан томилолт	1 896 000,00	3 252 000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3 869 173,00	7 484 521,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3 499 468,00	5 946 921,00
210803	Даатгалын үйлчилгээ	150 000,00	457 100,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00,00	1 000 000,00
210807	Газрын төлбөр	79 705,00	80 500,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	865 555,00	974 092,46
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	865 555,00	974 092,46
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00,00	1 709 000,00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00,00	1 709 000,00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00,00	1 709 000,00
2200	Дотоод эх үүсвэрээр	00,00	1 709 000,00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00,00	1 709 000,00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00,00	-1 709 000,00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00,00	00,00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00,00	00,00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00,00	00,00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00,00	00,00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	123 743 500,00	1 417 126,88	58 629 207,38	183 789 834,26
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	123 743 500,00	1 417 126,88	58 629 207,38	183 789 834,26
C07	Тайлант үеийн үр дүн	1 756 000,00	00,00	42 576 290,25	44 332 290,25
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	137 214 500,00	1 417 126,88	65 037 277,63	203 668 904,51
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	137 214 500,00	1 417 126,88	65 037 277,63	203 668 904,51
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	137 214 500,00	1 417 126,88	65 037 277,63	203 668 904,51
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	99 702 820,49	99 702 820,49
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	137 214 500,00	1 417 126,88	164 740 098,12	303 371 725,00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	199 262 300,00	198 940 207,54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	199 262 300,00	198 940 207,54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	199 262 300,00	198 940 207,54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	155 467 300,00	155 453 008,00
210101	Үндсэн цалин	88 532 800,00	88 532 800,00
210102	Нэмэгдэл	54 286 500,00	54 286 500,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11 448 000,00	11 433 708,00
210104	Урамшуулал	1 200 000,00	1 200 000,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3 388 500,00	3 309 916,86
210205	Эрүүл мэндийн даатгал	3 388 500,00	2 684 914,24
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12 192 200,00	12 123 441,68
210301	Гэрэл, цахилгаан	822 200,00	820 622,68
210302	Түлш, халаалт	10 647 800,00	10 647 780,00
210303	Цэвэр, бохир ус	722 200,00	655 039,00
2104	Хангамж, бараа материалын зардал	9 704 000,00	9 608 512,00
210401	Бичиг хэрэг	2 048 200,00	2 056 250,00
210402	Тээвэр, шатахуун	4 856 200,00	4 828 573,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	967 800,00	944 983,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1 831 800,00	1 778 706,00
2105	Нормативт зардал	1 698 600,00	1 674 248,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1 698 600,00	1 674 248,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6 532 500,00	6 520 560,00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	592 700,00	592 700,00
210604	Урсгал засвар	5 939 800,00	5 927 860,00
2107	Томилолт, зочны зардал	3 262 500,00	3 252 000,00
210702	Дотоод албан томилолт	3 262 500,00	3 252 000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7 016 700,00	6 998 521,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5 463 000,00	5 460 921,00
210803	Даатгалын үйлчилгээ	457 100,00	457 100,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	16 100,00	00,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1 000 000,00	1 000 000,00
210807	Газрын төлбөр	80 500,00	80 500,00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	199 262 300,00	198 940 207,54
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	195 962 300,00	194 988 207,54
131001	Улсын төсвөөс санхүүжих	195 962 300,00	194 988 207,54
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3 300 000,00	3 952 000,00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3 300 000,00	3 952 000,00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	08,00	08,00
620001	Удирдах ажилтан	01,00	01,00
620002	Гүйцэтгэх ажилтан	07,00	07,00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	9 509 500,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	9 509 500,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	9 509 500,00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	800 500,00
210104	Урамшуулал	-	800 500,00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	1 514 000,00
210401	Бичиг хэрэг	-	1 000 000,00
210402	Тээвэр, шатахуун	-	514 000,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	6 709 000,00
210602	Тавилга	-	1 709 000,00
210604	Урсгал засвар	-	5 000 000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	486 000,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	486 000,00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	9509500,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	9 509 500,00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	7 000 000,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	2 509 500,00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Шүүхийн шинжилгээний алба нь эрүү, иргэн, захиргааны хэрэг болон бусад хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримтыг илрүүлж, бэхжүүлж авах, ул мөр, эд мөрийн баримтад үзлэг шинжилгээ хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргах үйл ажиллагаа эрхлэн явуулдаг, Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа байгууллага юм.

Байгууллагын эрх зүйн орчинг боловсронгуй болгон, үйл ажиллагааг цахимжуулж, албан хаагчдын мэргэжлийн ур чадвар, ажиллах нөхцөл, удирдлагын манлайллыг дээшлүүлэх зорилт тавин ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж,гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт,тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Шүүхийн шинжилгээний албаны 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 99,702.8 мянган төгрөгөөр буюу 32.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Бараа материал	2747.9	3,299.4	551.5
Үндсэн хөрөнгө	200,921.0	300,072.3	99,151.3
Нийт хөрөнгө	203,668.9	303,371.7	99,702.8
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	203,668.9	303,371.7	99,702.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	203,668.9	303,371.7	99,702.8

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 300,072.3 мянган төгрөг болж, 99,151.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд ТӨБЗГ-ын 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 449 дүгээр тогтоолоор “Хөдөө аж ахуйг дэмжих сан”-гийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй байсан 151.9 сая төгрөгөөрийн үнэ бүхий Сонато-7 маркийн 28-47 УНУ улсын дугаартай автомашиныг балансаас балансад шилжүүлэн авч, ТӨБЗГ-ын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А-1/2482 тоот албан тоотын 1 дүгээр хавсралтад заагдсан 31.9 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй 04-96 СУА улсын дугаартай пургон маркийн автомашиныг Ховд аймгийн Шүүхийн шинжилгээний албанд хүлээлгэн өгсөн.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 163.9 сая төгрөг буюу 51 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан орлого байна. Энэ нь үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө 128.1 сая төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал өмнөх оноос 34.3 сая төгрөгөөр буюу 15 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, нэмэгдэл цалин, унаа хоолны хөнгөлөлт болон урамшуулалтай холбоотой зардал байна. Цалингийн зардал 3.1 сая төгрөгөөр буурсан боловч нэмэгдэл цалин 13.6 сая төгрөг, унаа хоолны нэмэгдэл 4.5 сая төгрөг, урамшууллын зардал 2.0 сая төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 202,311.2 мянган, үйл ажиллагааны орлогоос 3,300.0 сая, нийт зарлагыг 205,611.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн төслийн саналаас 6,349.0 мянган төгрөгөөр бууруулж, 199,262.3 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 11 зорилт, хөтөлбөрийн 54 арга хэмжээг санхүүжүүлэхээр 205,471.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 195,962.2 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр, нэмэлт санхүүжилтийн орлогоор 9,509.5 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70707-80101- Шүүх шинжилгээ	199,262.3	195,817.8	3,444.5	98.30%
НИЙТ		199,262.3	195,817.8	3,444.5	98.30%

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд ЗДНХ, түүнтэй адилтгах хөрөнгөөс 7,000.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт 2,509.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна. Нэмэлт санхүүжилтаар Цалингийн урамшуулалд 800.5 мянган төгрөг, Бичиг хэргийн зардалд 1,000.0 мянган төгрөг, Тээвэр шатахууны зардалд 514.0 мянган төгрөг, Тавилга эд хогшил авахад 1,709.0 мянган төгрөг, Урсгал засвар 5,000.0 мянган төгрөг, Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээнд 486.0 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.4 Төсөл, хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Миндүг Аудит” ХХК-ийн гүйцэтгэх захирал /МНБ, аудитор/ С.Энхтөр, аудиторын туслах Д.Сарнай нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Б.Бүзмаа Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер Г.Даваа, тус газрын Дарга, Тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны 130/09 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов..

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 1.0 хувиар буюу 1,736.0 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 1,350.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1¹, 15.2.3²-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд 1,081.8-6,994.5 мянган

¹ байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

төгрөгөөр өссөн байна. Тухайлбал: Тээвэр, шатахууны зардал 3,157.6 мянган төгрөг, Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс 1,081.8 мянган төгрөг, урсгал засварын зардал 6,994.5 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Дээрх зардлууд өмнөх оноос нэмэгдсэн учир шалтгааныг авч үзвэл:

- Тээвэр шатахууны зардал: Шатах тослох материалын үнэ өмнөх оноос дунжаар 52.0 хувиар нэмэгдсэн нь гол нөлөөлөл үзүүлсэн байна.
- Урсгал засварын зардал: Байрны урсгал засвар хийж, байрны дээврийн өнгийг сэргээн будаж, коридор, үүдний хэсгийн засвар, 6 өрөөний хаалгыг сольж шинэчилсэнтэй холбогдуулан урсгал засварын зардал нэмэгдсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Сүхбаатар аймгийн Шүүхийн шинжилгээний алба нь 2022 онд нийт 195,962.3 мянган төгрөгийн 19 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цаг хугацаанд нь ил тод байршуулж иржээ. Цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш төгрөгийн зарцуулалт байхгүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Шүүхийн шинжилгээний албанд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн залруулга, албан шаардлагыг 100% бүрэн хэрэгжүүлсэн байна.

² сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;

Зөвлөмжөөр өгсөн элэгдлээр өртгөө нөхсөн 17 нэр төрлийн 35,659.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг холбогдох эрх бүхий байгууллагуудаас зөвшөөрөл авч данснаас хасах зөвлөмж өгсөн. Актлаж, данснаас хасах саналыг ТӨБЗГ-т хүргүүлсэн боловч ямар нэгэн шийдвэр гаргаж өгөөгүйн улмаас уг зөвлөмж биелээгүй байна.

Хүснэгт 3 Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Залруулга	2	13,881.8	2	13,881.8	100%
Албан шаардлага	1	2,385.9	1	2,385.9	100%
Зөвлөмж	1	35,659.3	-	-	-
Нийт дүн	4	51,927.0	4	16,267.7	66.6%